

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 03
ДУГААР УЛИРАЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.09.25

Байгууллагын гүйцэтгэсэн ажлын мэдээг долоо хоног бүр БОАЖЯам болон ЗДТГ-т цахимаар хүргүүлэн ажиллаж байна.

ЗГазрын 2022 оны 02 тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.5,3.8-д заасны дагуу 2024 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого болон зарцуулалтын төлөвлөгөөг сум тус бүрээр байгаль орчны мэдээллийн сан/<https://finance.eic.mn/>-гийн БНАТ-1, БНАТ-2А маягийн дагуу оруулан аймгийн Засаг даргад, аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгуулах байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлийн саналаа аймгийн ЗДТГазрын ХБТХОХэлтэс тус тус хүргүүлэн ажиллав.

Алтай, Бугат сумдын нутаг дэвсгэрт орших булаг шандын эхийг хашиж хамгаалах ажлын сонгон шалгаруулалтыг 2023 оны 09 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн 2023 оны 10-р сарын 04-ний хүртэл зарлагдаад байна.

32 иргэн, ААНэгж байгууллагын төслийн баримт бичигт БОНБЕҮнэлгээний дүгнэлт, “Хабааж”ХХК, “Жибек жол”ХХК, “Баавгайн хөндий”ХХК-иудад 2023 онд ус ашиглуулах дүгнэлт гаргаж хүргүүлэв.

Аймгийн хэмжээнд гадаргын усний тооллогын судалгааны ажлыг сумдын ЗДТГазартай хамтран зохион байгуулаж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР:

Ногооннуур сумын 3-р багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаад түр зогссон “ЮУШИЭНГМИНГ”ХХК-ийн эзэмшилд байгаа Дулаан хар уурхайд хадгалагдаж байгаа 30-40 орчим тонн Цайрын сульфат, содны хадгалалт, хамгаалалтын байр нь стандартын шаардлага хангахгүй ил задгай агуулахад хадгалсан зарчлийг илрүүлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, Зөрчлийн тухай хуулийн 5.11-р зүйлийн 1.1.6-д заасны дагуу торгуулийн арга хэмжээ авч зөрчил арилгуулах хугацаат эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч зөрчлийг ойрын хугацаанд арилгуулах даалгавар өгч ажиллав.

Аймгийн Прокурорын газраас 01/741 тоот албан бичгээр Б/273 дугаартай гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгаад хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэн, зөрчлийн шинжтэй үйлдэлд нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахаар ирүүлсэн материалтай холбогдуулан БОАЖГ-11 дугаартай зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж хууль бусаар 182 ширхэг буюу 455.95 кг байгалийн жамаар унасан халиун бугын эвэр түүж бэлтгэн худалдаж, худалдан авсан зөрчил үйлдсэн 3 иргэнийг нийт 900,000 / есөн зуун мянган төгрөг/ төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлого болох 14,000,000 /арван дөрвөн сая төгрөг/ төгрөгийг улсын орлого болгуулахаар аймгийн Санхүү төрийн сангийн дансанд тушаалгахаар шийдвэрлэв. Хураан авсан 182 ширхэг бугын эврийг улсын орлого болгуулахаар Өлгий сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлж ажиллав.

Өлгий сумын 6,11-р баг, Сагсай сумын төвд “ил задгай хог хаягдал шатааж байна” гэх мэдээллийн мөрөөр тус сумуудын БОХУБайцаагчид хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж зөрчил гаргасан иргэдийг тус бүр 50.000 төгрөгөөр торгож, зөрчлийн үр дагаврыг арилгуулж ажиллав.

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/319 тоот “Үндэсний Их баяр наадмыг тохиолдуулан зохион байгуулах салбар хороо байгуулах тухай” захирамжаар батлагдсан “Байгаль орчин, хог хаягдал, ариун цэврийн асуудал хариуцсан салбар хорооны наадмын өдрүүдэд хийх ажлын төлөвлөгөө”-ний дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг холбогдох байгууллагуудтай хамтарч аймгийн төв цэнгэлдэх хүрээлэн болон морь барианы газрын орчны эрүүл ахуйн нөхцөл байдалд шалгалт хийж, зарим цэвэрлэгдээгүй газруудад гүйцэд цэвэрлэгээ хийх, хогийн савыг хүрэлцээтэй хэмжээгээр байршуулах, нүхэн жорлонд ариутгал халдваргүйтгэл хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгүүлэхээр холбогдох байгууллагуудад үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж ажиллалаа.



Долоодугаар сарын 18-ны орой орсон хүчтэй аадар борооны улмаас Өлгий сумын 2, 3,4,12,13 дугаар багуудад буусан үерийн хор уршгийг арилгах арга хэмжээний хүрээнд байгууллагын албан хаагчид үерийн усыг тогтоосон газарт асгах, гарсан хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт буулгах ажилд хяналт тавьж ажиллав. Нийт 10 тонны даацтай камаз маркийн машинаар 104 удаа, 20 тонны HOWO маркийн машинаар 40 удаа үеэрт автагдсан газрыг цэвэрлэгээнээс үүссэн хог хаягдлуудыг ачиж, хогийн цэгт буулгах ажлыг Өлгий сумын ЗДТГ, Авто тээврийн төвтэй хамтран гүйцэтгүүлэв.



Аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/453 дугаар Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай захирамжийн хуваарийн дагуу БОАЖГазар болон сумдын БОХУБайцаагч, байгаль хамгаалагчид ОБГазар, Цагдаагийн газар, Зооноз өвчин судлалын төвийн албан хаагч нартай хамтран хариуцсан нутаг дэвсгэрт Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тогтмол эргүүлд гарч хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, ард иргэдэд холбогдох хууль тогтоомжуудыг сурталчлан ажиллав. Хяналт шалгалт хийх явцад Толбо, Сагсай, Цэнгэл, Буянт, Бугат, Дэлүүн сумын нутаг дэвсгэрээс нийт хууль бусаар 98 ширхэг тарвага агнасан 14 зөрчлийг илрүүлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллаж байна.




ХЭАХУБайцаагч, БОАЖГ-ын мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарын бүрэлдэхүүнтэй аймгийн хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний жижиглэн худалдааны үйл ажиллагаа явуулж буй "Рысжан" ХХК, "Ник-Петровис"ХХК, "Магнай Трейд" ХХК, "Шунхлай" ХХК, "Хазына" ХХК, "Өлгий ойл" ХХК,"Тэс-Петролиум" ХХК, "Хөрс-Автосервис" ХХК-иуд, Алтай сумын "Алтай-Петро", "Сырмөлдир", Буянт сумын "Хажымас Хайрат", "Буянт ойл", Сагсай сумын "Ер Айдын", Цэнгэл сумын "Ой", "Молкен", Улаанхус сумын "Тастыбулах" шатахуун түгээх станциуд зэрэг нийт 46 ШТС-ыг хяналт шалгалтанд хамруулж, хөрсний бохирдол үүсгэгч нүхэн жорлонгийн хэрэглээг зогсоох, стандартын шаардлагад нийцсэн нийтийн ариун цэврийн байгууламж барих, ангилан ялгах хогийн сав байршуулах талаар улсын байцаагчийн хугацаат 93 заалт бүхий 10 албан шаардлага өгч, мэргэжил арга зүйн зөвлөөгөөр ханган

ажилласаны үр дүнд нийт 43 ширхэг ШТС-ын стандартын шаардлага хангасан эко жорлон барьж ашиглалтад оруулав.



2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон БОАЖЯ-ийн Салбарын хяналтын газрын даргын баталсан 01/08, 01/14 удирдамжийн дагуу аймгийн БОАЖГазар, Өлгий сумын байгаль орчны хяналтын улсын /ахлах/ байцаагчид хамтарч аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа НААУ “СУАТ”ХХК, “Эрчим”ХХК, “Балбалтас”ХХК, “Угур”ХХК, “Хабаж”ХХК, “Күнгей”ХХК-ийн авто засварын газар, “Синдес Айдар” ХХК-ийн “Самал” авто засварын газар, “Дос авто сервис” авто засварын газар, “Даян” авто сервис, “Азат” ХХК-ийн мал төхөөрөх, мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, “Баавгайнхөндий” ХХК-ийн жуулчны бааз, “Алтай экспедишинс” ХХК-ийн жуулчны баазын үйл ажиллагаанд 01.1.4 кодтой “Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-аар нийт 26 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг тус тус хийж, эрсдэлийг үнэлж ажилласан ба илэрсэн зөрчилтэй холбогдуулан улсын байцаагчийн хамтарсан 119 заалт бүхий 12 албан шаардлага хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.



БОАЖЯамны салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 04-р сарын 6-ны өдрийн 01/06 дугаар удирдамж, 2023 онд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран баталсан удирдамжийн дагуу аймгийн БОАЖГ-ын байгаль орчны хяналтын улсын /ахлах/ байцаагчид, холбогдох мэргэжилтнүүд хамтарч Алтай, Сагсай, Цэнгэл, Улаанхус, Буянт суманд хяналт шалгалтаар ажиллав. Шалгалтаар тус сумын удирдлагуудад Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай, Амьтны тухай, Хог хаягдлын тухай хуулиуд болон БОАЖСайдын 2023 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилт, аймгийн Засаг даргын 2023 оны 08-р сарын 16-ны өдрийн “Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай” А/453 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулах, жижиглэнгийн үйл ажиллагаа явуулдаг ШТС-иудыг ангилан ялгах хогийн савтай болгох, хөрс бохирдуулагч нүхэн жорлонг буулгаж, стандартын шаардлага хангасан эко жорлонтой болгох талаар шаардлага тавьж, байгаль орчны багц хуулиудыг сурталчилан таниулах ажил зохион байгуулан иргэдийн санал бодлыг сонсож, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 9 төрлийн сэрэмжүүлэг бүхий 300 ширхэг гарын авлага тарааж ажиллалаа.






Аймгийн төвд үйл ажиллага явуулж байгаа ус ашиглагч 27 аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалт хийж, зөвшөөрөлгүй ус ашиглаж байгаа ААНэгжүүдэд Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулан ажиллахыг шаардаж ажиллав.



СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:

Байгаль орчны багц хууль, аялал жуулчлал, Тарваган тахал өвчинөөс урьдчилан сэргийлэх талаар орон нутгийн олон нийтийн радиогоор болон хэвэл мэдэллээр сурталчлах ажлыг зохион байгуулав.



Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд, 13 сумдын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Байгаль орчны чиглэлээр гарсан хууль тогтоомж, стандарт, журам, дүрэм зэргийг сурталчлан таниулах, мэдлэг олгох, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор цахим сургалтыг зохион байгуулж, мэдээлэл өгч ажиллав.



Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2022 оны 02 дугаар албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/368 дугаартай “Цэвэр-цэмцгэр-Өлгий” аян зохион байгуулах захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд Хог хаягдлын тухай хуулийг бүх түвшинд сурталчлах, дахин боловсруулах хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах хог хаягдлыг ангилан ялгаж сургах зорилгоор Өлгий сумын төвд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн, нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд аймгийн ЗДТГазар, БОАЖГазар, Өлгий сумын ЗДТГазар, МАНУТХГНХЗахиргаа хамтран 1000 гаруй Алтай, Сагсай, Цэнгэл, Улаанхус, Ногооннуур сумын 400 гаруй сурагчидад сургалт зохион байгуулж, брошур болон урамшуулалын ном, гарын бэлэг тараах ажлыг зохион байгуулав.



Азийн хөгжлийн банкны "Агаарын чанарыг сайжруулахтай холбоотой мэдлэг, үйл ажиллагааг бэхжүүлэх" төслийн хурал, семинар, Говь-Алтай аймагт зохион байгуулсан “Хариуцлагатай уул уурхай” өдөрлөгт, Төрийн албаны зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйн өөрчлөлт бүтээмжид нөлөөлөх нь” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт байгууллагын холбогдох албан хаагчидыг, БОАЖЯам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор орон даяр зохион байгуулсан Байгаль

орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал, мэдээллийн сангийн цахим сургалт, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй "Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессийг боловсронгуй болгох, үндэсний чадавхыг бэхжүүлэх (NAP) " төслийн газраас зохион байгуулсан "Үндэсний дасан зохицлын төлөвлөгөөний орон нутгийн хэлэлцүүлэг", Газрын багц хууль, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд боловсруулагдаж байгаатай холбогдуулан аймгийн ЗДТГазар, "Нээлттэй нийгэм форум"-тай хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэг холбогдох мэргэжилтнүүд, сумдын БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нарыг оролцуулав.



ОЙН ТАЛААР:

Баян-Өлгий аймгийн ойн сан бүхий Алтай, Алтанцөгц, Цэнгэл, Баяннуур Бугат, Булган, Ногооннуур, Дэлүүн суманд ойн хөнөөлт шавж, өвчний судалгааны ажил болон Цэнгэл сумын хушны ойн сангийн төлөв байдалд үнэлгээ өгөх, хамгаалах, нөхөн сэргээх талаарх судалгааны ажлыг "Байгаль орчны тогтвортой хөгжлийн санаачлига" ТББ-тай хамтран хийж гүйцэтгэв. Судалгааны явцад Цэнгэл суманд орших "Ховд голын сав газрын дагуух шинэсэн ойд Якобсоны төөлүүрч эрвээхэйн голомт ажиглагдсан ба ойн сэргээн ургалт сайн байгаа учир орон нутагт ажиглалт, тандалт хийхээр тус сумын БОХУБайцаагч, байгаль хамгаалагч нарт мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Засгийн газрын хэрэг эрхлэх агентлаг болох Ойн газраас хэрэгжүүлж буй мод үржүүлгийн газруудын улсын тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулав.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААР:

2023 оны 09-р сарын 01-ны байдлаар тус аймагт 26 орны гадаадын 21445, дотоодын 28000 нийт 49445 аялагчид зорин ирсэн ба үүнээс АТБогд, Хотон, Хурган нуур Бага түргэний хүрхрээний чиглэлд 16500 аялагчид зорисон бол бусад аялагчид Толбо нуур, Цамбагарав, Хөх сэрхий нуруу, Ачит нуур зэрэг газруудыг зорьсон судалгаатай байна.

БҮРГЭДИЙН БАЯР: Алтай, Сагсай, Улаанхус, Толбо, Алтанцөгц сумуудад ЗДТГазар, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажилагаа явуулдаг ААНэгжүүд болон сумдын бүргэдийн холбоотой хамтран “Бүргэдийн баяр” зохион байгуулав.



Аялал жуулчлалын болон амралт зугаалгын улирал эхэлсэнтэй холбогдуулан БОАЖЯам болон Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос өгсөн чиглэлийн дагуу аймгийн хэмжээний байгалийн үзэсгэлэнт газрууд, уул овоо, зам дагуух ил задгай хаясан хог хаягдлыг тогтмол цэвэрлэх ажлыг сумдын ЗДТГазруудтай хамтран зохион байгуулж, хийсэн ажлын талаарх тайланг заасан хугацаанаас өмнө хүргүүлэн ажиллав.

"ИХ АЛТАЙ, ГРИТ АЛТАЙ-2023" АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, СПОРТЫН НААДАМ

2023 оны 08-р сарын 10-наас 19-ний хооронд тус аймагт Монгол, ОХУ, БНКазахстан, БНХАУ, Беларус гэсэн 5 улсын төлөөлөл, баг тамирчидын дунд рафтинг, уулын авиралт, загасчлах спорт, олс таталт, мотоциклийн аяллын тэмцээн, нордикийн алхалт, усны аяллын тэмцээн, явган аялал, гар барилдаан, бухаша тартыс зэрэг спортын төрлүүдээр зохион байгуулагдсан тус наадамд байгууллагын албан хаагчид бэлтгэл ажлыг хангаж ажиллав.






БОАЖСайдын ажлын бүрэлдэхүүн тус аймгийн БОАЖГазар, УЦУОШТөв, МАНУТХГНХЗахиргаа, Хөх Сэрхийн НУТХГХЗахиргааны албан хаагчидтай уулзалт зохион байгуулж, байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр хийж буй арга хэмжээний тухай санал солилцлоо.

Гадаад дотоодын жуулчдын тоо нэмэгдсэнээр байгалийн унаган төрх алдагдах эрсдэлтэй тул байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж зарим тусгай хамгаалалттай газар нутагт авто машинтай нэвтрэх хязгаарын бүсийг тогтоох, хэрэгцээ шаардлагатай байгааг БОАЖСайд онцоллоо.

Уг арга хэмжээнд байгууллагын бүх албан хаагч нарыг оролцуулав.

Тус аймагт 2023 оны 07-р сарын 31-ны байдлаар 26 орны гадаад 21487, дотоодын 20800 нийт 42287 жуулчид ирсэн судалгаатай байна.



АН АМЬТНЫ ТАЛААР:

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 06 дугаар сарын 22-ны “Хуваарь батлах тухай” А/215 дугаар тушаалаар тус аймагт хуваарилагдсан тусгай зориулалтаар агнах, барих 15 толгой Алтайн угалз, 28 толгой Тэх, 5 толгой Халиун буга, 8 толгой Зэгсний зэрлэг гахай, үйлдвэрийн зориулалтаар 15 тонн Алтайн Сугас загас агнах, барих зөвшөөрөл олгох цахим дуудлага худалдааг аймгийн ЗДТГазрын хурлын зааланд аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг цахимаар зохион байгуулж, ялагч бүртэй Амьтны тухай хууль болон Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн А/242 тоот тушаалаар батлагдсан гэрээний загварын дагуу гэрээ байгуулан, зөвшөөрөл олгож байна. 2023 оны 09-р сарын байдлаар 14 угалз, 5 халиун буга, 20 тэх агнагдсан болно.

2023-2028 оны аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөний судалгааний ажлыг “Агнуур судлалын нийгэмлэг” ТББ-тай хамтран аймгийн хэмжээний 38 агнуурын бүс нутгуудад хийж гүйцэтгэв.



ХОГ ХАЯГДЛЫН ТАЛААР:

БОАЖСайдын 02 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын А/368 дугаар захирамжийн хүрээнд том оврын ангилан ялгах 2 ширхэг хогийн савыг аймгийн ЗДТГазраас зардлыг гарган хийлгэж, төв талбайд байршуулан ХТАлбанд хүлээлгэж өгч ажиллав. Иймд ард иргэд хог хаягдлыг ангилан ялгаж хаяхыг уриалж байна. Ангилсан хог хаягдлыг ХТАлба ачуулаад Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд тушаах арга хэмжээ авч ажиллах юм. Аймгийн төв рүү орох, гарах пост болон Цагааннуур чиглэлийн зам дагуу сурталчилгааны самбарууд байршуулав.



Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2022 оны 02 дугаар албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/368 дугаартай “Цэвэр-цэмцгэр-Өлгий” аян зохион байгуулах захирамжийг хэрэгжүүлэх хүрээнд Хог хаягдлын тухай хуулийг бүх түвшинд сурталчлах, байгаль орчноо цэвэрлэх, дахин боловсруулах хог хаягдлыг байгальд шууд хаяхгүйгээр эргүүлэн ашиглах, дахин боловсруулах хог хаягдлыг ангилан ялгаж сургах зорилгоор Өлгий сумын төвд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн, нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн дунд 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулна.

ангийн ялгаж, дахин боловсруулах, уралдааны явцад хэрэгжүүлсэн аялал талаар болон хог хаягдлын талаар контент хийж байгууллагын цахим хуудас, олон нийтийн телевиз, радиогоор сурталчилсан байх.

Уралдааны шалгаруулалт:
Уралдаанын зохион байгууллагын болон аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, эрэлтийг оруулалтын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нэр дараах оноогоор үнэлж, дүннэж.

1. Хог хаягдал ангиан ялгах хөнгөн сав байгуулагдсан байдал (30 оноо)
2. Хөнгөн ангиан ялгах, хуванцар дахин боловсруулах шил, лааз, варенье, архины шил тушаасан байдал (25 оноо)
3. Хог хаягдлын ангиан ялгах хэвшилтэй болох 2-оос доошгүй удаа арга хэмжээ зохион байгуулах /Хуванцар, нэг удаагийн хэрэглээнээс татгалзах, дахин ашиглаж талаар ойлголт өгөх бүтээл хийж, сурталч, г.м/ байдал (20 оноо)
4. Хэрэгжүүлсэн аялал байгууллагын цахим хуудас тусгаар байгуулагын Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг тэмдэглэн /mention/ олон нийтэд таниулсан гайж, шейрын тоогоор (15 оноо)
5. 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 16.00 цаг хүртэл тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлсэн байдал (10 оноо)

Шалгалтын сан:
Эхний 6 байр эзэлсэн аж ахуйн нэгж байгууллагад дараах шагналыг олгоно.

- 1 дүгээр байр: Өргөмжлөл, 1 000 000 төг
- 2 дугаар байр: Өргөмжлөл, 600 000 төг
- 3 дугаар байр: Өргөмжлөл, 300 000 төг
- Тусгай байр-2 тус бүр Өргөмжлөл, 150 000 төг

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 88535677, 99423395 ДУГААРЫН УТСААР ТОДРУУЛНА УУ.



“ХОЛИВОЛ ХОГ, АНГИЛБАЛ БАЯЛАГ” УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Үндэслэл: Байгаль орчны хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2023 оны 02 дугаар албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/368 дугаартай “Цэвэр-цайгар-Өлгий” аян зохион байгуулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын сайн аж ахуйн нэгж, байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн дунд зохион байгуулахад оршино.

Зорилго: Хог хаягдлын тухай хуулийг бүх түвшинд сурталчлах, байгаль орчноо цэвэрлэх, дахин боловсруулах хог хаягдлыг байгальд шууд хаяжгүйгээр эргүүлэн ашиглах, дахин боловсруулах хог хаягдлыг ангиан ялгаж сургахад оршино.

Хамрах хүрээ: Баян-Өлгий аймгийн Өлгий сумын бүх аж ахуйн, нэгж байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг.

Хугацаа: 2023 оны 09 дугаар сарын 11-ний өдөрөөс 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулна.

Танигдах шаардлага: Уралдаанд оролцогчид дараах үйл ажиллагааг заагдсан хугацаанд зохион байгуулсан байх ба цаашид өөрсдийн байгууллагын хог хаягдлыг ангиан ялгаж Хог томируулах албанд тушааж.

1. Өөрсдийн байгууллагын гадна хог хаягдал ангиан ялгах хөнгөн сав хийлгэж байршуулах, хог хаягдлыг ангиан ялгаж хэвшсэн байх.
2. Хөнгөн ангиан ялгах, хуванцар дахин боловсруулах шил, лааз, варенье, архины шил /АПУ/ Хот томируулах албанд тушаасан байх. /Хаягдал тушаах хүний утасны дугаар /А.Айбек – 94311661/
3. Хог хаягдлын ангиан ялгах хэвшилтэй болох 2-оос доошгүй удаа арга хэмжээ зохион байгуулах /Хуванцар, нэг удаагийн хэрэглээнээс татгалзах, дахин ашиглаж талаар ойлголт өгөх бүтээл хийж, сурталч, г.м/
4. Бусад аж ахуйн нэгж, байгууллага, ард иргэдэд хог хаягдлын хор уршиг,



Манай аймагт ХӨБРОДОГЧ түүхий эд авдаг газрууд



| | |
|----------------------------------|----------------------------------|
| Вороний өм-1а – 150 төг | Иргэн Бабалуур Ерэг |
| • Хойбоо Баруун утас нь: 9422202 | • Ажилтныг 4000-2500 төг |
| • Ажилтныг 9422202 | • Ажилтныг 1г – 300 төг |
| • Формат: 9429852 | • Дас 1г-1000 төг |
| | • Тууль-1г-400 төг |
| | • Лааз-1г-100 төг |
| | • Хойбоо Баруун утас нь: 9422202 |

Өлгий сумын КТА-ба

- Хуванцар
- Гөмжигүүрт

Хойбоо Баруун утас нь: 9422115

Аймгийн төв орж гарах 2 чиглэлд хог хаягдлын талаар анхааруулга бүхий 2 ширхэг мэдээллийн самбар хийлгэж байршуулан, хог хаягдлын талаар 2 шторк хийлгэж, сурталчлах ажлыг зохион байгуулав.



БОАЖСайдын 02 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын А/368 дугаар захирамжийн дагуу хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд аймгийн хэмжээгээр айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага, жуулчны бааз, иргэдийн ажиллуулдаг эко гэр, рашааны нүхэн жорлон, стандарт шаардлага хангасан ариун цэвэр, угаадасны нүхний тооллого зохион байгуулав. Үүнд аймгийн хэмжээнд нийтдээ 18865 нүхэн жорлон, 516 стандарт шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, 12895 угаадасны нүх тоологдсон болно.



Аймгийн засаг даргын А/368 захирамж "Цэвэр цэмцгэр Өлгий" аяны хүрээнд хөрсний нян, бактер, хүнд металлын бохирдлын түвшинг тогтоох зорилгоор 15 цэгээс нян бактерийн, 6 цэгээс хүнд металлын дээж авч аймгийн Стандарт хэмжил зүйн газрын лаборатори болон Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторт хөрсний нян, бактер, хүнд металлын шинжилгээнд хамруулахаар дээж явуулсан. Уг шинжилгээнд Өлгий сумын төвийн 4, 5, 6, 8, 12, 13 багууд болон Буянт, Бугат, Сагсай сумууд хамрагдав.



БОАЖСайдын 02 дугаар албан даалгавар, Аймгийн засаг даргын А/368 захирамж "Цэвэр цэмцгэр Өлгий" аяны хүрээнд Өлгий сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт хамаарах 0.28га газрын удаан жил хуримтлагдсан 200 гаруй тонн үнс болон хог хаягдлыг цэвэрлэж хогийн цэгт буулгах ажлыг хийж гүйцэтгэв.



"ACT for women" төслийн хүрээнд Ерөнхий боловсролын лаборатори 2-р сургуулийн багш, сурагчид Ховд гол орчмын хогыг түүж, байгальд хогоо хаяхгүй байхыг уриалж ажиллав. Уг арга хэмжээнд МАНУТХГХЗахиргаатай хамтран ерөнхий боловсролын багш, сурагчдад хог

хаягдлын байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар мэдээлэл өгч, сурталчилгааны материал тарааж ажиллав.



Баяр наадам, амралт, аялал жуулчлалын үеэр БОАЖ-ын Сайдын 02,04,05-р албан даалгаврын биелэлтийг хангах зорилгоор аймгийн байгалийн үзэсгэлэнт газрууд, зам дагуу болон уул овооны хог хаягдлыг цэвэрлүүлэх арга хэмжээг сум тус бүрээр зохион байгуулав. Үүнд:


Цэнгэл суманд: үйл ажиллагаа буй жуулчны баазын орчим, уул овоо, Байтас рашаан, Ховд голын эрэг болон зам дагуу хуримтлагдсан эзэнгүй хог хаягдлуудыг тус сумын байгаль хамгаалагчид 2 удаа цэвэрлэж нийт 5 тонн хог хаягдлыг сумын нэгдсэн хогийн цэгт ачиж зайлуулан ажиллав.



Алтанцөгц суманд: Сумын аялал жуулчлалаар хүмүүс их очидог газар болох Цамбагарав уулын орой дээр байгаа Хоёр толгой болон Ганц улиас, Зуслан, Тэхт, Таван бэлчир, зэрэг газруудын зам дагуу байгаа архины шил ундааны сав зэрэг хог хаягдлыг тус сумын байгаль хамгаалагчид сумын ЗДТГ-ын ажилчдад хамтран цэвэрлэгээний ажлыг зохион байгуулав.



Толбо сум: Толбо нуурын амралтын газрын ойр орчмын 20 гаруй тонн хог хаягдлыг 2 удаа цэвэрлэж хогийн цэгт буулгав.



Улаанхус суманд: сумын цагаан хаалганы ойр орчмын хог хаягдлыг 2 удаа цэвэрлэж зайлуулах ажлыг тус сумын багаль хамгаалагчид хийж гүйцэтгэв.



Цагааннуур тосгон: Аймгийн засаг даргын А/368 захирамж Цагааннуур тосгоны захирагчийн А/27 дугаар захирамжийн дагуу "Цэвэр цэмцгэр Сум" аяны хүрээнд тосгоны 5- дугаар хэсэг болох Улаанбайшинт орох замын 2 тал болон хогийн савын хог хаягдлыг цэвэрлэж, Мөн албан байгууллагууд, үйлчилгээний газрууд болох гуанз, дэлгүүр болон ард иргэдийг аянд идэвхтэй уриалан оролцуулж нийт 5тонн хог ачиж хогийн цэгт буулгах ажлыг хийж гүйцэтгэв.



БОАЖСайд тус аймагт ажиллах үеэр Ногооннуур сумын нутагт байрлах Цагааннуураас 500 метрийн зайд 1970 оноос хойш үүссэн хогийн цэгийг устгалд оруулах албан даалгавар өгөгдсөний дагуу Орон нутгийн хөгжүүлэх сангийн 40 сая төгрөгийн санхүүжилтээр хогийн цэгийн түрэг, нэгдсэн хогийн цэгт буулгах ажлыг “Баян-Сан зам”ХХК хийж гүйцэтгэв.



Буянт сум: 2,4-р багийн Засаг дарга нартай хамтран сумын А бүс, Сагсай голын ай сав болон Хасагтын дээд доод талын овоогийн хогийн савь байгаа хогийг цэвэрлэж ажиллав. Нийтэй 2.5тн хог ачив.



Бугат суманд: төвөөс Хасбаатарын хөшөө хүртэл эзэнгүй хог хаягдлыг тус сумын ЗДТГ-ын албан хаагч нартай хамт зохион байгуулж, 4 тонн гаруй малын сэг зэм, хог хаягдлыг нэгдсэн хогийн цэгт хүргэж ажиллав.



Дэлүүн суманд: үхэж хорогдсон мал амьтны сэг зэмийг устгах ажлыг зохион байгууллаа.



Баяннуур: БОАЖСайдын 2023 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор энэ сарын 13-ны өдөр Баяннуур сумын аялал жуулчлалын бүс, угтах хаалга, зам дагуух эзэнгүй хог хаягдлыг тус сумын байгал хамгаалагч Ж.Ерболат 4 байгууллагын 8 албан хаагчтай хамт цэвэрлэж, нийт 1.5 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт буулгаж ажиллаа.



Үндэсний их баяр наадмын үеэр хүүхдүүдэд хогны уут тарааж, нэг уут хогийг 1000₮-өөр худалдан авах, стадионы хаананд “Цэвэрхэн наацагаая!” уриалга зуруулах, Морины барианы газар болон Стадионы гадаа 6 ширхэг том оврын хогийн пункер болон 15 ширхэг хогийн савнуудыг холбогдох байгууллагуудтай хамтран байршуулан ард иргэдэд хогоо хогийн саванд хаяж, цэвэрхэн наадахыг уриалж ажиллав.



Олон Улсын Атомын Энергийн Агентлаг, Цөмийн энергийн комисс, Боловсрол, шинжлэх ухааны яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны радоны эрсдэлт бүс нутгийн зураглал боловсруулах” төслийн хүрээнд БОАЖЯамнаас ирүүлсэн радоны агуулгыг тодорхойлох детекторыг хүлээн авч, 12 сумын байгаль хамгаалагч, байцаагч нарт радон детекторыг хэрэглэх зааварчилгааны хамт хүлээлгэж өглөө.



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР